



“БиДиСЕК”ХК-ИЙН НООГДОЛ АШГИЙН ЖУРАМ

Нийтлэг үндэслэл

Энэхүү журмаар “БиДиСЕК” ХК-ийн хөрөнгө оруулагчдад ашиг хуваарилах ноогдол ашгийн бодлого, ноогдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Энэхүү ноогдол ашгийн журмыг компанийн ТУЗ-өөс боловсруулан батлаж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглана.


Энэхүү журам нь тухайн үе дэх хувьцаа эзэмшигчид болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад компанийн ашиг хуваарилалтын бодлого, хэмжээ, хуваарилах арга хэлбэрийн талаар тодорхой нэгдсэн ойлголтыг хүргэнэ.

Нэг. Ноогдол ашгийн бодлого

1. Компани нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, жил бүр ноогдол ашгийн хэмжээг өсгөн зохистой түвшинд байлгах зорилготой ажиллана.
2. Компанийн ноогдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн батлана.
3. Компани тухайн санхүүгийн жилд ноогдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнаж, ноогдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ноогдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө танилцуулна.
4. Компани үйл ажиллагааны ашгаас хөрөнгө оруулагчдад ноогдол ашиг хуваарилахдаа ноогдол ашгийг бэлэн мөнгө, үнэт цаас, биет эд хөрөнгөөр олгож болно.

Хоёр. Ашгийн хэмжээг тодорхойлох

1. Ноогдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан үзүүлэлт байна.
2. Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ноогдол ашигт хуваарилж байна. Энэхүү дүн нь компанийн тухайн жилийн цэвэр ашгийн 20%-иас доошгүй хэмжээтэй байна.



3. Бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр ноогдол ашиг тараах тохиолдолд тухайн эд хөрөнгө, үнэт цаасны үнэлгээг ТУЗ-өөс тогтооно.

Гурав. Ноогдол ашиг хуваарилах

1. Ноогдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
2. Компани хувьцаа эзэмшигчиддээ бэлэн мөнгөөр ноогдол ашиг хуваарилахдаа хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансаар дамжуулан нэгдсэн журмаар олгоно.
3. Ноогдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ноогдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой зааж, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусдаг байна.

Дөрөв. Мэдээлэл хүргэх

1. Тухайн жил тараасан ноогдол ашгийн хэмжээ болон тараах журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдэгдэн, компанийн веб хуудсаар дамжуулан нийтийн хүртээл болгохоос гадна ТУЗ-ийн нарийн бичгээр дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.

